

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 13 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны арван нэгдүгээр сарын 05-ны өдрийн 11 цаг 23 минутад эхэлж, 12 цаг 35 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 12 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Луус сумын Соёлын Төвийн эрхлэгч, Өлзийт Сайнцагаан, Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай.	Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Намсрайн Бадамцэцэг 60,8 оноогоор тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тул нэр дэвшүүлж, холбогдох материалыг Сайхан-Овоо сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.
2	Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газрын Сайхан-Овоо, Сайнцагаан сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Сайхан-Овоо сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцөд бүртгэлтэй Өлзийхутагийн Хуланг, Сайнцагаан сум хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Чимэгсүхийн Сэржмядагийг тус тус нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв
3	Дундговь аймгийн зарим нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцийн зард зарлуулах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 2, туслах түшмэлийн 3 нийт 5 сул орон тоог нөөцийн зард зарлуулахаар шийдвэрлэж, ТАЗ-д хүргүүлэхээр болов
4	Луус сумын Соёлын Төвийн эрхлэгч, Өлзийт, Сайнцагаан, Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай.	Луус сумын Соёлын Төвийн эрхлэгч, Өлзийт Сайнцагаан, Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 12 дугаар сарын 04-05 –ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэж, материалыг ТАЗ-д хүргүүлэхээр болов.
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн Ц.Идэр-Оргилын буцаасан тухай	Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд Ц.Идэр-Оргилыг нэр дэвшүүлсэн Төрийн албаны зөвлөлийн тус салбар зөвлөлийн 2018 оны 50 дугаар тогтоолыг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ